# АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ГЭРЭЭ

| | | |
|---|---|---|
| 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдөр | дугаар АӨҮА-2014/01/01 | Улаанбаатар хот |

## Ерөнхий зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Ашигт Малтмалын Газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас XV-007240 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улаанбаатар хотын Үндэсний татварын ерөнхий газарт бүртгэлтэй, аж ахуйн нэгжийн 9011257048 тоот гэрчилгээ, 5428904 регистрийн дугаартай "Эс Пи Жи" ХХК (цаашид Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэнэ) нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 078 тоот тушаалаар батлагдсан Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмыг үндэслэн Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумдын нутагт орших Толийн (Талын) салаагийн алтны шижирмэг бүлгийн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үеийн хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## Нэг. Гэрээний нөхцөл, хугацаа

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
   a. Ордыг ашиглах зураг төсөл боловсруулах;
   b. Ордын нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулах;
   c. Уурхай барьж байгуулах;
2. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг 2016 оны 8 дугаар сарын 01-ний дотор хийх.
3. Ордын технологийн туршилтын хугацаа 1 жил байна.
4. Орд ашиглах төслийн хүчин чадалд хүрэх хугацаа 3 жил байна.
5. Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумдын нутагт орших Толийн (Талын) салаагийн заагийн алтны шижирмэг бүлгийн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр дуусгавар болгоно.

## Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт нөхөн төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахаас өмнө Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 48-д заасныг үндэслэн АМГ-ын даргын 2009 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан АМГ-ын ГСХ-ийн "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн хайгуулын ажлын жилийн тайлан хүлээн авах, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг тооцох" дотоод зааврын дагуу жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хайгуулын ажлын тайланг ГСХ-т хүргүүлж хайгуулын ажлын доод

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

хэмжээг баталгаажуулж, хуулбарыг гэрээний биелэлтийн тайлангийн хамт гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ( 1 ) жил тутам УУСХ-т ирүүлнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлттэй холбоотойгоор АМГ-аас үзлэг, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрлэлийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.

5. Орд ашиглахтай холбогдсон баримт бичгийг Монгол хэл дээр үйлдсэн байна.

6. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд гарч байгаа зардлуудыг татварын албанд тушаасан тухай мэдэгдлийг тайланд тусгасан байна.

7. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үед хайгуул судалгааны ажил хийгээгүй талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу буцааж өгөх.

8. Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцөлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

## Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай хүсэлтийг бичгээр хүргүүлнэ.
2. Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.
3. Гэрээний заалтуудын биелэлтэд үзлэг, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.
5. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг бичгээр авсан байна.

## Дөрөвдүгээр зүйл. Бусад зүйл.

1. Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, шийдвэр (гэрээний заалтууд бүрэн биелсэн акт)-ийг үндэслэн гэрээлэгч талууд хамтран дүгнэж акт үйлдэнэ.
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагаврыг бүрэн хариуцна.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг АМГ-тай хамтран дүгнээгүй тохиолдолд ашигт малтмалын XV-007240 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

5. Гэрээг 3 /гурав/ хувь үйлдсэн бөгөөд 1 /нэг/ хувийг АМГ-ын Уул уурхайн асуудал хариуцсан нэгжид, 1 /нэг/ хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 /нэг/ хувийг кадастрын бүртгэлийн төвийн архивт тус тус хадгална.

6. Энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарах маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| **Ашигт малтмалын газрыг төлөөлж:** | **Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:** |
| **Уул уурхайн хэлтсийн** | **"Эс Пи Жи" ХХК-ийн захирал** |
| **дарга.......................С.Баттулга** | **............................................ Ли Чинь Нин** |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

147

# АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгэл хийгдэж байгаатай холбогдуулан нэг талаас Ашигт малтмалын газар /цаашид АМГ гэх/, нөгөө талаас Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумдын нутагт орших Толийн /Талын/ салаагийн алтны ордын XV-007240 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн эзэмшигч “Эс Пи Жи” ХХК-тай байгуулсан №АӨҮАГ-2014/01/01 тоот гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн (№АӨҮАГ-2014/01/01) тоот гэрээний салшгүй хэсэг байна.

1 Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумдын нутагт орших Толийн /Талын/ салаагийн алтны ордын талбайн ашигт малтмалын хайгуулын XV-007240 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр дуусгавар болно.

2. Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг үндсэн гэрээ байгуулах үед мөрдөж байсан хуулийн дагуу төлөх буюу төлбөрийн хэмжээ 1 гектар тутамд 1.5 америк доллар байна.

3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийг мөрдөж ажиллана.

4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнд оруулах энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн хавсралтанд шинэчлэн бүртгүүлсэн тухай тэмдэглэгээ хийлгэнэ.

| | |
|---|---|
| **Ашигт малтмалын газрыг төлөөлж:** | **Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:** |
| **Уул уурхайн хэлтсийн дарга** | **“Эс Пи Жи” ХХК-ийн захирал** |
| **................................. С.Баттулга** | **..................... Ли Чинь Нин** |

УЛААНБААТАР ХОТ

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Ашигт малтмал газрын тосны газар
Кадастрын хэлтэс

**Тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл**
**ТЗ-ийн дугаар: XB-007240**

## айгуулын тусгай зөвшөөрөл:

| | | | |
|---|---|---|---|
| Эзэмшигч: | Эс Пи Жи | Олгосон огноо: | 2004.04.12 |
| Талбайн нэр: | Хорт уул | Дуусах огноо: | 2015.05.25 |
| Талбайн хэмжээ: | 1623.95 Га | Барьцаалсан байдал: | --- |
| Байршил: | Увс (Өмнөговь; Тариалан) | Шүүхэд хэлэлцэгдэж буй эсэх: | --- |
| Ашигт малтмал: | --- | Планшетийн дугаар: | M-46-88 |

## Өргөдлүүд:

| Код | Төрөл | Бүртгэсэн огноо | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| XV-007240-000-CI | [CI] Цэгцлэгдсэн өгөгдөл | 2010.02.09 | 47-Албадан хийсэн хөдөлгөөнийг эцэслэх |
| XV-007240-001-NE | [NE] Шинэ хайгуулын тусгай зөвшөөрөл | 2004.03.25 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-002-TF | [TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Эс Пи Жи) | 2004.11.29 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-003-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2005.04.14 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-004-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2006.04.10 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-005-EE | [EE] Хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгах | 2007.03.28 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-006-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2007.03.09 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-007-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2008.04.08 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-008-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2009.04.06 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-010-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2010.03.01 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-011-EE | [EE] Хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгах | 2010.03.11 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-012-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2010.04.22 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-013-TF | [TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Дацантрейд) | 2010.10.06 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-014-TF | [TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Гүүдком) | 2010.12.23 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-015-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2011.04.13 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-016-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2012.04.12 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-017-NM | [NM] Шинэ ашиглалтын тусгай зөвшөөрөл | 2013.12.20 | 29-Татгалзсан өргөдлийг эцэсл |

Хэвлэсэн огноо: 2016.10.04 14:58

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 73 | 2016.06.14 | 02/3755 | БОНХАЖЯ | 4638 | Мэдээлэл хүргүүлэх тухай | 2016.06.20 | БОНХАЖЯ-наас УУЯ-д хүргүүлсэн мэдээлэлтэй танилцав. | Хадаад 09.05 |
| 74 | 2016.06.22 | 16/26 | Хунан жинлэн ХХК | 4826 | МҮ-20546 АТЗ-ийн талбайн ЭХБ-д олборлолт явуулах дүгнэлт гаргуулах | 2016.06.24 | Цэгц | Хадаад 09.05 |
| 75 | 2016.06.24 | 04/4076 | БОНХАЖЯ | 4937 | Ажлын хэсгийн дүгнэлтийн тухай /1/3803 тоотын хариу/ | 2016.06.30 | Цэгц | Хадаад 09.05 |
| 76 | 2016.07.07 | 07/14 | Эм Жи Эйч ХХК | 5157 | Гэрээ байгуулах тухай 9258А, 7207А | 2016.07.08 | утас 681226 | Хадаад 09.05 |
| 77 | 2016.07.07 | 07/56 | Монгол газар ХХК | 5158 | Гэрээ байгуулах тухай 2426А, 2427А, 5529А | 2016.07.08 | утас 70001435 | Хадаад 09.05 |
| 78 | 2016.02.05 | 01/21 | Болдтөмөр ерөө гол ХХК | 1210 | Хүсэлт гаргах нь 5/796 тоотын хариу | 2016.02.15 | Мөнхсайхан | Хадаад 09.05 |
| 79 | 2016.03.02 | 2016/0302 | Ти энд Ти Юникс ХХК | 1774 | МҮ-002244, МҮ-004323 хүсэлт гаргах нь | 2016.03.03 | Мөнхсайхан | Хадаад 09.05 |
| 80 | 2016.05.23 | 5/2102 | Хууль зүйн яам | 4058 | А/67, А/96 тушаалууд бүртгэгдээгүй тухай | 2016.05.25. | Мөнхсайхан | Хадаад 09.05 |
| 81 | 2016.09.02 | 25 | МБГЦ ХХК | 469 | Хүсэлт гаргах тухай 12500А | 2016.09.05 | | |

4543

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Ашигт малтмал газрын тосны газар
Кадастрын хэлтэс

**Тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл**
**ТЗ-ийн дугаар: XB-007240**

| | | | |
|---|---|---|---|
| XV-007240-018-AP | [AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа | 2014.01.06 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-019-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2014.01.17 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-020-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | 2014.01.24 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-021-AP | [AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа | 2014.12.03 | 19-Батлагдсан өргөдлийг эцэсл |
| XV-007240-022-FE | [FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр | | 11-Тусгай зөвшөөрлийн төлбөр |
| XV-007240-023-RN | [RN] Хуулийн 56.1.1-2, 56.1.4-5 дагуу цуцлах | 2015.05.25 | 47-Албадан хийсэн хөдөлгөөнийг эцэслэх |

## Эзэмшигчийн бүртгэл:

Нэр: Эс Пи Жи
Аж ахуйн нэгжийн төрөл: хязгаарлагдмал хариуцлагатай компани
Бүртгэлийн дугаар: 5428904
Улсын бүртгэлийн дугаар #: 9011257048
Улс: Монгол
Захирлын овог, нэр: LI CHENNING LI CHENNING

Утас: ---
Гар утас: 9999-8838, 8804-5888
Факс: ---
Е-мэйл: L13911353520@126.com; uranzurag@yahoo.com

## Эзэмшигчийн хаяг:

Гудамж: 86-29 тоот
Хот: Улаанбаатар
Аймаг/ Хот: Улаанбаатар
Сум/ Дүүрэг: Хан-Уул
Баг/ Хороо: 16

Шуудангийн хайрцаг: ---
ZIP код: ---

## ТЗ-ийн солбицол:

| Олон өнцөгт | # | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | град | мин | сек | град | мин | сек |
| Ex1 | 1 | 91 | 46 | 34.09 | 49 | 30 | 1.78 |
| Ex1 | 2 | 91 | 46 | 34.17 | 49 | 29 | 31.73 |
| Ex1 | 3 | 91 | 47 | 4.18 | 49 | 29 | 31.73 |
| Ex1 | 4 | 91 | 47 | 4.18 | 49 | 29 | 56.74 |
| Ex1 | 5 | 91 | 47 | 29.17 | 49 | 29 | 56.72 |
| Ex1 | 6 | 91 | 47 | 29.17 | 49 | 29 | 31.73 |

Хэвлэсэн огноо: 2016.10.04 14:58

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | 2016.05.16 | 1/5727 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 3815/1591 | Уул уурхай, судалгааны хэлтсийн даргын 2011.12.15-ны 5-7359 тоот албан бичгийн хуулбар, Алтан төхөм ХХК-ийн нөхөх олговор авах тухай АМГ-т ирүүлсэн хүсэлтийг ирүүлэх тухай | 2016.05.18 | 2016.05.24 5/3393 тоотоор хариу хүргүүлэв. | Хадаад 09.05 |
| 61 | 2016.05.17 | 01/456 | Алтай констракшн ХХК | 3818 | Итгэмжлэл олгох тухай | 2016.05.18 | Танилцав. | Хадаад 09.05 |
| 62 | 2016.05.19 | 19/2016 | Өү Жи Си Эйч Эл ХХК | 3900 | ХҮ-007560 АӨҮАГ дүгнүүлэх тухай | 2016.05.28 | ӨҮАГ дүгнэсэн акт №2016/ | Хадаад 09.05 |
| 63 | 2016.05.23 | 16/08 | Эс Эйч Юу Ти ХХК | 4012/1715 | ХҮ-016674 АӨҮАГ дүгнүүлэх тухай | 2016.05.27 | | |
| 64 | 2016.05.24 | 01/464 | Алтай констракшн ХХК | 4049 | Гэрээ байгуулах тухай МҮ-014548 | 2016.05.27 | | |
| 65 | 2016.05.30 | 1/6313 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 4196/1806 | Алтан төхөм ХХК-ийн материалыг хуулбар үнэн гэж баталгаажуулах | 2016.06.06 | 2016.06.10-ны өдөр 5/3702 тоотоор хариу хүргүүлэв. | |
| 66 | 2016.05.25 | 4272 | Эрдэс холдинг ХХК | 4272 | АӨҮАГ дүгнүүлэх тухай ХҮ-007875 | 2016.06.06 | ХҮ-007875 АӨҮАГ дүгнүүлэх тухай | Хадаад 09.05 |
| 67 | 2016.06.03 | 2016/06 | Болор шүр ХХК | 4301/1857 | Хүсэлт гаргах тухай МҮ-016658 | 2016.06.06 | Ажлын хэсэг /Д.Эрдэнэтунгалаг/ газар дээр нь ажилласан. | Хадаад 09.05 |
| 68 | 2016.06.02 | 16/21 | Шар нарст ХХК | 4310/1862 | МҮ-012094 АТЗ-ийг буцаан авах тухай | 2016.06.06 | МҮ-012094 АТЗ-ийг хавсралтын хамт хүлээлгэж агав. | Хадаад 09.05 |
| 69 | 2016.06.03 | 78 | Скарн ХХК | 4314 | МҮ-004404 АТЗ-ийн талбайд газар дээр нь танилцаж дүгнэлт гаргуулах тухай | 2016.06.06 | Ажлын хэсэг /Д.Эрдэнэтунгалаг/ газар дээр нь ажилласан. | Хадаад 09.05 |
| 70 | 2016.06.03 | 16/05 | Өргөн цагаан нуур ХХК | 4334/1875 | МҮ-012229 дүгнэлт гаргуулах тухай | 2016.06.16 | 2016.06.17-ны 5/3860 тоотоор хариу хүргүүлэв. | Хадаад 09.05 |
| 71 | 2016.06.07 | 03 | Вэн Чөн ХХК | 4414/1903 | МҮ-006066 Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст тодорхойлолт гаргуулах тухай | 2016.06.09 | 2016.06.17-ны 6/3854 тоотоор хариу хүргүүлэв. | Хадаад 09.05 |
| 72 | 2016.06.07 | 12/28 | Монзол ХХК | 4428 | МҮ-008664 АТЗ-ийг буцаан авах тухай | 2016.06.13 | 2016.06.14-ний өдөр МҮ-008664 АТЗ-ийг хавсралтуудын хамт захирал Ч.Чинбатад хүлээлгэн өгөв. | Хадаад 09.05 |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ex1 | 7 | 91 | 50 | 9.18 | 49 | 29 | 31.73 |
| Ex1 | 8 | 91 | 50 | 9.18 | 49 | 29 | 1.72 |
| Ex1 | 9 | 91 | 42 | 59.17 | 49 | 29 | 1.74 |
| Ex1 | 10 | 91 | 42 | 59.1 | 49 | 30 | 26.79 |
| Ex1 | 11 | 91 | 47 | 29.09 | 49 | 30 | 26.79 |
| Ex1 | 12 | 91 | 47 | 29.09 | 49 | 30 | 21.79 |
| Ex1 | 13 | 91 | 46 | 59.1 | 49 | 30 | 21.79 |
| Ex1 | 14 | 91 | 46 | 59.1 | 49 | 30 | 1.79 |



ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | 2016.04.20 | 01/10 | Шинэ шуудан | 3129 | Нөхөх олговор авах хүсэлт гаргах тухай ХҮ-015433 | 2016.04.27 | ГА нөхөх олговрын материалыг СЯ-д хүргүүлэхээр бэлтгэж бна. | Хадаад 09.05 |
| 50 | 2016.04.26 | 25 | Хулморьт майнинг | 3224 | АӨҮАГ дүгнүүлэх тухай ХҮ-007337 | 2016.04.27 | АӨҮАГ 2016.04.27 2016/9 | Хадаад 09.05 |
| 51 | 2016.04.26 | 26 | Хулморьт майнинг | 3225 | АӨҮАГ дүгнүүлэх тухай ХҮ-007334 | 2016.04.27 | АӨҮАГ 2016.04.27 2016/9 | Хадаад 09.05 |
| 52 | 2016.04.26 | 24 | Хулморьт майнинг | 3226 | АӨҮАГ дүгнүүлэх тухай ХҮ-014843 | 2016.04.27 | АӨҮАГ 2016.04.27 2016/9 | Хадаад 09.05 |
| 53 | 2016.04.25 | 19 | Ю энд Би ХХК | 3229 | МҮ-002810 АТЗ буцаан авах тухай | 2016.04.27 | Г.Булган даргад МҮ-002810 АТЗ нь ОС дээр олборлолтын үйл ажиллагаа явуулах боломжтой тухай БОНХАЖ-ын сайдын тушаалыг үндэслэн АТЗ-ийг хүлээлгэн өгөв 2016.04.28 | Хадаад 09.05 |
| 54 | 2016.04.27 | 10/16 | Геопро монгол ХХК | 3291 | МҮ-015632 АТЗ-ийн хэсэгчлэн цуцлагдсан талбайг буцаан авах тухай | 2016.05.09 | 2016.05.24 5/3380 тоотоор хариу хүргүүлэв. | Хадаад 09.05 |
| 55 | 2016.04.27 | 04/16 | Алтан шагай групп ХХК | 3315 | МҮ-000169 АТЗ-ийг буцаан авах тухай | 2016.04.28 | 2016.05.03-д захирал О.Заяад эх хувь, 2ш хавсралтын хамт хүлээлгэж өгөв. | Хадаад 09.05 |
| 56 | 2016.05.02 | 01/08 | Бага таян ХХК | 3445/1356 | МҮ-000150 АТЗ-ийн хэсэгчлэн буцаан өгсөн талбайг эргүүлэн авах тухай | 2016.05.09 | 2016.05.24 5/3379 тоотоор хариу хүргүүлэв. | Хадаад 09.05 |
| 57 | 2016.05.06 | 1/33 | Барилга орд ХХК | 3567 | МҮ-013331 гэрээ байгуулах тухай | 2016.05.10 | МҮ-013331 АТЗ-ийн талбайтай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргуулах тухай | Хадаад 09.05 |
| 58 | 2016.05.09 | 01/02/51 | Гуравт ХХК | 3588/1450 | МҮ-005648 АТЗ-ийг буцаан авах тухай | 2016.05.09 | МҮ-005648 АТЗ-ийн эх хувийг 6ш хавсралтын хамт хүлээлгэж өгөв. | Хадаад 09.05 |
| 59 | 2016.05.12 | 01/450 | Алтай констракшн ХХК | 3765 | 12721, 14759, 14760 АТЗ-үүдийг буцаан авах тухай | 2016.05.17 | 12721, 14759, АТЗ-үүдийг буцаан олгосон. | Хадаад 09.05 |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

# АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛСОН ТУХАЙ АКТ №2016/22

2016.10.04

Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумын нутагт орших Толийн (Талын) салаагийн алтны шижирмэг бүлгийн ордын XV-007240 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл нь Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 406 тоот тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.1-2, 56.1.3-4 дэх заалтыг үндэслэн цуцлагдсан тул Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмын 6.1.3-д заасны дагуу Ашигт малтмалын газар /одоогийн АМГТГ/ болон “Эс Пи Жи” ХХК нарын харилцан тохиролцож байгуулсан 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн №АӨҮА-2014/01/01 тоот ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээг дуусгавар болгов.

Жич: АМГ-ын Кадастрын хэлтсийн CMCS программаас XV-007240 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг хуулбарлан хавсаргав.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ХАНГАЙ

УХА0595
532353 1116 128255

Боловсруулсан: УУҮТХ-ийн мэргэжилтэн Г.Оюунтуяа

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN